

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2022/108/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Аудитор: Б.Уранбилэг Утас: 70523020 Цахим хаяг: uranbileg.b@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.02.23 № 16/88

танай _____-ны № _____-т

АЙМГИЙН ШҮҮХИЙН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Т.ДАВААДОРЖ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	12.8	23.0
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,015.5	1,095.0
	Нийт хөрөнгийн дүн	1,028.3	1,118.0
	Нийт өр төлбөрийн дүн		9.8
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн		1,108.2
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,028.3	1,118.0
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,210.3	1,252.5
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,142.3	1,172.7
	Үйл ажиллагааны үр дүн	68.0	79.8
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	Үйл ажиллагааны нийт үр дүн	68.0	79.8
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	960.3	1,028.3
	Тайлант оны үр дүн	68.0	79.8
	Эцсийн үлдэгдэл	1,028.3	1,108.1
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,110.6	1,114.1
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,097.2	1,098.9
	Үйл ажиллагааны ЦМГ	13.4	15.2
	Хөрөнгө оруулалтын ЦМГ		
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		1,099.1
	Урсгал зардал		1,099.1
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		1,099.1
	Улсын төсвөөс санхүүжих		1,099.1
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газар нь нь шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд хөндлөнгөөс оролцохгүйгээр Шүүхийн захиргааны тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлж, дараах үндсэн үйл ажиллагааг эрхэлнэ: Үүнд:

- Шүүгчийн хараат бус байдлыг хангаж, хамгаалах;
- Шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах;
- Шүүхийн хүний нөөцийг удирдах;
- Шүүхийн төсөв, санхүү, дэд бүтцийг удирдах;
- Шүүхийн нээлттэй байдлыг хангах, олон нийттэй харилцах зэрэг болно.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль нь 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөр хүчингүй болсон байна. Энэ хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т “Тухайн шүүгчийн цалингийн хэмжээ шүүгчээр ажилласан тав дахь жилээс эхлэн жил бүр өмнөх оныхоос хоёр хувиар нэмэгдэж байна” гэж заасан байна. Харин Монгол Улсын Шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 16 дугаар зүйлд “2012 оны 3 дугаар сарын 07-ны өдөр баталсан Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 23.2-т заасан бүх шатны шүүхийн шүүгчийн цалингийн нэмэгдэлтэй холбогдох заалтыг 2021 оны төсвийн жил дуусах хүртэл хугацаанд дагаж мөрдөнө” гэж заасны дагуу 2021 оныг дуустал шүүгчийн цалингийн нэмэгдлийг олгосон байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 129.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 0.5 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлсэн байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй байна.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 9.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 9.1 сая төгрөгийн алдааг залруулж, зөрчил арилгах 1 зөвлөмжийг хүргүүлэв.

4.1 Залруулсан алдаа

1. Мөнгөн гүйлгээний журналыг шүүд үзэхэд 9,089.2 мянган төгрөгийн ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулаагүй, шууд зардалд бүртгэж тайлагнасан байна. Үндсэн

хөрөнгийн тодруулга тайлангаар 20,036.9 мянган төгрөгөөр хөрөнгө худалдан авсан байтал мөнгөн гүйлгээний тайланд тусгагдаагүй байна.

4.2 Зөвлөмж

Бараа материалын данстай холбоотой

- 1.1. Илрүүлэлт: Тайлант хугацаанд бараа материалын тайланг шалгахад бараа материалын тайлан программ дахь бүртгэлийг хэвлэж архивласан байна. Мөн дээрх хэвэлмэл тайланг нягтлан бодогч, нярав баталгаажуулж гарын үсэг зураагүй байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 374 дүгээр тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын холбогдох хэсгийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- 1.2. Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2017 оны 374 дүгээр тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын БМ-9 маягтаар бараа материалын тайланг гаргах.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	9.1	1	9.1					1	2
1	ТШЗ	2	9.1	1	9.1					1	2
	НИЙТ	2	9.1	1	9.1					1	2